

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТАРИАЛАН
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
КР-1 ТӨСЛИЙН ДАРГА В.ҮНЭНБАТ
ТАНАА

2020.02.20 № 06/534
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төсөл нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн гүйцэтгэх захирал В.Үнэнбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн удирдлага санхүүгийн тайлан, тодруулга тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Б энд С аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, Чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Б энд С аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний 01/11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Япон улсын Засгийн газраас хүнсний тусламж, бага орлоготой тариаланч, фермерүүдийг дэмжих, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тусламжийн хүрээнд “Хүнсний хангамжийг сайжруулах КР-1 төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд эргэн төвлөрсөн хөрөнгийг “Хуримтлалын орлогын сан”-д төвлөрүүлж, мөн Засгийн газар хооронд солилцсон НОТ бичигт зааснаар нийгэм эдийн засгийн хөгжилд сангийн хөрөнгийг зарцуулахаар тодорхойлж, ядуурлыг бууруулах, жижиг фермерүүдийг дэмжихэд оршино.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хөрөнгийг Япон улсын Засгийн газартай зөвшилцсөний дагуу зарцуулж, 6 сар тутам дэлгэрэнгүй тайланг хүргүүлдэг байна. Салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр тодорхой төслүүдийг боловсруулан Япон улсын Засгийн газарт Элчин сайдын яамаар дамжуулан хүсэлт хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр хөрөнгө зарцуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Америкийн нэгдсэн улсын “Quick book 2010” программ хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тохруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,901,645.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 29,016.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,913,903.5 мянган төгрөгөөр буюу 91.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,016,282.1		-1,016,282.1
Авлага	31,799,267.1	2,901,645.8	-28,897,621.3
Нийт хөрөнгө	32,815,549.2	2,901,645.8	29,913,903.4
Өр төлбөр	5,212.2	4,212.2	-1,000.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	41,581,780.5	41,581,780.5	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	32,815,549.2	2,901,645.8	29,913,903.4

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авах авлага 26,863,429.8 мянган төгрөг, КР-2 төслөөс авах авлага 2,034,191.5 мянган төгрөгийн төсөл хооронд үүссэн өр авлагыг өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу цэвэрлэх бичилт хийсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд:

- 2003 оны жилийн эцэст Төрийн сангийн дансанд байршиж байсан 1,518,518.6 мянган төгрөгийг Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн,
- Сүүний төслийн 2 дугаар үе шатны хүрээнд 2008 онд олгогдсон хөнгөлөлттэй зээл болон сүүний тоног төхөөрөмжийн зээлийн авлага 1,255,388.8 мянган төгрөг,
- Япон улс, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 02 дугаар сарын 18-ны НОТ хэлэлцээрийн дагуу 2012 онд орж ирсэн цагаан будааны борлуулалтын зээлийн авлагын үлдэгдэл 112,673.6 мянган төгрөг,
- Анод банкны эрх хүлээн авагчаас 2013 оны 11 дүгээр сарын 12-нд ирсэн албан тоотын дагуу дансны үлдэгдэл хааж 15,064.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зэрэг нийт 2,901,645.8 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Үүнээс: Сүү төслийн зээлийн үлдэгдэл 136,000.0 мянган төгрөг, цагаан будааны өрийн үлдэгдэл 85,250.0 мянган төгрөг нийт 221,250.0 мянган төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гаргуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь данс андуурсан 1,000.0 мянган төгрөгийн гүйлгээг буцааснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд эзэн холбогдогч нь тодорхойгүй 4,212.2 мянган төгрөгийг тодруулахаар 2017 оны 06 дугаар сарын 27-ны 01/486 дугаар албан бичгээр Төрийн банкинд хандсан боловч одоог хүртэл хариу өгөөгүй байна

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төслийн удирдлага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Тайлант жилд ажил гүйлгээ гараагүй, төсөл хоорондын өр авлагыг өмнөх аудитын зөвлөмжийн дагуу цэвэрлэх бичилт хийж, 2020 онд хаалтын баланс хийхээр төлөвлөн Японы Засгийн газарт хүсэлт хүргүүлсэн байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн хэрэгжих хугацаа 2020 онд дуусах тул өр авлагын үлдэгдлийг аж ахуйн нэгж, иргэн бүрээр тулган баталгаажуулах шаардлагатай байна.

Тухайн байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд зээлийн хүүгийн орлого, өр шилжүүлснээс өөр ажил гүйлгээ хийгдээгүй тул зөвлөмж өгөх асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 97 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 30,172,287.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 26,867,642.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, 3,304,645.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс 28,897,621.3 мянган төгрөгийн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 95.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-1 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,815,549,239.11	2,901,645,787.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,016,282,114.61	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,016,282,114.61	-
3121	Төгрөг	1,016,282,114.61	-
31213	Арилжааны банк дахь харилцах	1,016,282,114.61	
33	АВЛАГА	31,799,267,124.50	2,901,645,787.43
33100	ТЭДС-аас авлага	26,863,429,837.07	
33200	КР-2 төслөөс авах авлага	2,034,191,500.00	
33300	Сангийн яамнаас авлага	1,518,518,662.00	1,518,518,662.00
33400	Сүү төслийн авлага	1,255,388,796.00	1,255,388,796.00
33401	Цагаан будааны авлага	112,673,600.00	112,673,600.00
33402	Анод банкны эрх хүлээн авагч	15,064,729.43	15,064,729.43
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	32,815,549,239.11	2,901,645,787.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,212,250.00	4,212,250.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,212,250.00	4,212,250.00
412	Богино хугацаат зээлийн өглөг	1,000,000.00	-
4121	Төгрөг	1,000,000.00	-
41217	Хятадын зээлийн бага оврын трактор	1,000,000.00	
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
414	Урьдчилж орсон орлого	4,212,250.00	4,212,250.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	4,212,250.00	4,212,250.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,810,336,989.11	2,897,433,537.43
51	Засгийн газрын хувь оролцоо	32,810,336,989.11	2,897,433,537.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,581,780,513.78	41,581,780,513.78
51101	Өмч: - төрийн	41,581,780,513.78	41,581,780,513.78
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
512	Хуримтлагдсан үр дүн	(8,771,443,524.67)	(38,684,346,976.35)
51210	Өмнөх үеийн үр дүн	(7,522,667,654.24)	(29,912,903,451.68)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,248,775,870.43)	(8,771,443,524.67)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	32,815,549,239.11	2,901,645,787.43

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	184,402,474.57	51,320,436.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	184,402,474.57	51,320,436.81
120	Нийтлэг татварын бус орлого	184,402,474.57	51,320,436.81
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	184,402,474.57	51,320,436.81
120003	Торгуулийн орлого		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,433,178,345.00	29,964,223,888.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,433,178,345.00	29,964,223,888.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,433,178,345.00	29,964,223,888.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	-	28,954,371,588.49
210406	КР-1 төсөл үйл ажиллагааны зардал		28,954,371,588.49
2107	Томилолт, зочны зардал	-	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500.00	16,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,500.00	16,500.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,433,176,845.00	1,009,835,800.00
213401	Бордооны төслийн санхүүжилт	1,433,176,845.00	1,009,835,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,248,775,870.43)	(29,912,903,451.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,248,775,870.43)	(29,912,903,451.68)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	185,402,474.57	51,320,436.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,402,474.57	51,320,436.81
120	Нийтлэг татварын бус орлого	185,402,474.57	51,320,436.81
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	184,402,474.57	51,320,436.81
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,433,178,345.00	1,009,852,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,433,178,345.00	1,009,852,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,500.00	16,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2107	Томилолт, зочны зардал	-	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500.00	16,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,500.00	16,500.00
210818	Сургалт семнарийн зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,433,176,845.00	1,009,835,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,433,176,845.00	1,009,835,800.00
213401	Бордооны төслийн санхүүжилт	1,433,176,845.00	1,009,835,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,247,775,870.43)	(958,531,863.19)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	57,750,251.42
230001	Эргэж төлөгдөх зээл		57,750,251.42
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(57,750,251.42)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,247,775,870.43)	(1,016,282,114.61)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,264,057,985.04	1,016,282,114.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,016,282,114.61	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,581,780,513.78		-7,522,667,654.24	34,059,112,859.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,581,780,513.78		-7,522,667,654.24	34,059,112,859.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			-1,248,775,870.43	-1,248,775,870.43
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,581,780,513.78		-8,771,443,524.67	32,810,336,989.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,581,780,513.78		-8,771,443,524.67	32,810,336,989.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			-29,912,903,451.68	-29,912,903,451.68
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,581,780,513.78		-38,684,346,976.35	2,897,433,537.43